

“СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ”-ИЙГ  
ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023.05.31-ний өдөр

Улаанбаатар хот

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 1386 сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа явуулж байгаагаас орон нутагт 148, Улаанбаатар хотод 1238 сууц өмчлөгчдийн холбоо байна.

Сууц өмчлөгчдийн холбоод нь нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, тухайн орон сууцны байшингийн ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах зорилгоо хэрэгжүүлэн оршин суугчдыг тав тухтай, эрүүл орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын яам нь Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, биелэлтэд хяналт тавих, холбооны үйл ажиллагааг дэмжих, холбооны үлгэрчилсэн дүрмийг батлах зэрэг бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, биелэлтэд хяналт тавих”, 17.1.4-д “холбооны үлгэрчилсэн дүрмийг батлах” нь орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх хэмжээнд хамаарахаар зохицуулсан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2014 оны 122 дугаар тушаалаар “Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрэм” батлан, тухайн үед Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх талаар хүсэлт хүргүүлсэн боловч бүртгэгдээгүй байна.

Шинээр байгуулагдаж буй сууц өмчлөгчдийн холбоод дүрэм боловсруулахад баримтлах эрх зүйн баримт бичиг байхгүй байгаагаас сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт сууц өмчлөгчдийн холбоод бүртгэл хийлгэхэд үл ойлголцол үүсэх хүндрэлтэй асуудал тулгараад байна.

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 34 дүгээр тушаалаар “Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрэм”-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Уг ажлын хэсгээс “Сууц өмчлөгчдийн холбооны үлгэрчилсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулаад байна.

---oOo---